



# АЛТАН ГАДАС ОДОНТ “ХОРИНХОЁР ДУГААР БААЗ” ХК

2024 оны 12 сарын 27 өдөр

№ 24/06

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ


*Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.16 болон 88.2 дахь заалт, “Хорин хоёрдугаар бааз” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 7.32.16 дахь заалт болон Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:


1. Тус компанийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө (цаашид “Худалдах үл хөдлөх эд хөрөнгө” гэх) тус бүрт нь үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргуулж, худалдан авах ирүүлсэн компанитай холбогдох үл хөдлөх эд хөрөнгө худалдах-худалдах авах гэрээ байгуулж шилжүүлэхтэй холбогдуулан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгож, гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатарт олгосугай.
2. Компанийн нэр дээр байгаа зарим үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахтай холбогдуулан үл хөдлөх эд хөрөнгийн дор байгаа Нийслэлийн Засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/546 дугаар шийдвэрийн дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр олгосон Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших нэгж талбарын 1331200616 дугаартай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /Орон сууц, худалдаа үйлчилгээ, сургууль цэцэрлэг/-ын зориулалттай нийт 62,968 м.кв газар эзэмших эрхийг энэ тогтоолын хавсралтад тусгасан кадастрын зургийн дагуу ойролцоогоор 49,000 м.кв орчим газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн зах зээлийн өрсөлдөхүйц үнээр худалдан авах санал ирүүлсэн этгээдэд, үлдэгдэл 13,968 м.кв газрыг худалдан авах санал ирүүлсэн этгээдэд зах зээлийн үнээр харилцан тохиролцож шилжүүлэх талаар холбогдох их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгож, гэрээ байгуулах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатарт олгосугай.
3. Худалдах үл хөдлөх эд хөрөнгийг дагаж газар эзэмших эрхийг шилжүүлж байгаатай холбогдуулан Худалдан авагч нарт шилжүүлэх үл хөдлөх эд хөрөнгө, түүний доорх газар эзэмших эрхийг хэсэгчлэн хуваасан кадастрын зураг хийлгэх, холбогдох гэрээний гол нөхцөлийг тохиролцох, хэлэлцээр хийх, гэрээний төслийг бэлтгэх, гэрээг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох үл хөдлөх эд хөрөнгийн болон эцсийн эзэмшил шилжүүлсэнтэй холбоотой албан татварыг төлөх асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатарт даалгасугай.


4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга Л.Гүндэгмаад даалгасугай.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА


  
/Л.ГҮНДЭГМАА/


ГИШҮҮД:

  
/Т.ЗОРИГТБААТАР/


  
/В.НОМУНДАРЬ/


  
/Л.ЭРДЭНЭЧУЛУУН/


  
/Т.ЭРДЭНЭБААТАР/

  
/Б.БАЯРСАЙХАН/

ХАРААТ БУС ГИШҮҮД:

  
/А.БААТАРЖАВ/

  
/Ю.ТУЯАЦЭЦЭГ/

  
/ЦЭНХТҮЯА/